



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/ЗЧ/9

Чингис хот

Зөвлөгөөний зардалд  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Чингис хотод зохион байгуулах “Зүүн болон говийн бүсийн аймгуудын зөвлөгөөн”-ний зардалд 10000000 /нэг сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Коронавирусын халдварын эрсдэлээс сэргийлж, холбогдох журмуудыг чанд баримтлан ажиллахыг аймгийн Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн салбар холбооны тэргүүн /Г.Цэнд/-д даалгасугай.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ